



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 518

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 36, 130 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Нийслэлийн прокурорын газар болон Тээврийн прокурорын газрын албан ажлын хэрэгцээнд зориулан нийт 280,000,000.00 (хоёр зуун наян сая) төгрөгт багтаан 2 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, харьяа Прокурорын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
5/8 дугаар тогтоолын хавсралт



**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЬЯА ПРОКУРОРЫН ГАЗАРТ
ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР**

д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
Нийслэлийн прокурорын газар				
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2488 cc хүртэл	1	160,000,000.00	160,000,000.00
Тээврийн прокурорын газар				
2	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2488 cc хүртэл	1	120,000,000.00	120,000,000.00
Нийт дүн				280,000,000.00
				(хоёр зуун наян сая)